



АХБ-ны Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн
төлөө Зүүн Азийн жендэрийн тэгш байдлыг
эрчимжүүлэх төсөл /ТА-6883 REG/

**“ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ
НОГООН САНХҮҮГИЙН
ХУВЬСАЛ ДАХЬ
ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН ОРОЛЦОО”
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Улаанбаатар хот, Монгол Улс
2023 оны 10-р сарын 26

АГУУЛГА

1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТӨЛӨВЛӨЛТ

2. МЭДЭЭЛЭЛ, ӨГӨГДӨЛ ЦУГЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**2а. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТНААС АВСАН СУДАЛГАА**

**2б. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮН БИЧИЛ, ЖИЖИГ
ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДЭЭС АВСАН СУДАЛГАА**

3. СУУРЬ СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

4. САНАЛ ЗӨВЛӨМЖ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААС АВСАН СУДАЛГАА

Судалгааны үе шат:

Тоон мэдээлэл цуглуулах



Тоон судалгаанд дүн шинжилгээ хийх

Чанарын мэдээлэл цуглуулах



Чанарын судалгаанд дүн шинжилгээ хийх

Судалгааны хамрах хугацаа:

2023 оны 02 сарын 20




2023 оны 06 сарын 09

Суурь тоон болон чанарын судалгааг явуулсан арга хэлбэр

Санал асуулга:

“Google form” (8-15 минут)

“Microsoft Excel”



СЗХ-ны ХЗХ-ны газрын 2021, 2022 онд гүйцэтгэсэн судалгаанд үндэслэн нийт 142 ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтнуудад цахилгаан шуудан илгээв.

ХЗХ-ны нэгдсэн мэдээллийг хэвлэж авсан цаасан дээр болон “Microsoft Excel” дээр давхар хөтлөв.

• Суурь чанарын судалгааг ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтан, гишүүдтэй ганцаарчилсан болон фокус группын ярилцлагыг утсан харилцаагаар, зайнаас хийж гүйцэтгэв.

Ганцаарчилсан, фокус группын бүх ярилцлагыг дуу хураагуурт (639МВ хэмжээтэй, .mp3 өргөтгөлтэй файл) бичиж, ярилцлагын тэмдэглэлийг давхар хөтлөв.

Судалгааны явц

- Утасны дугаар алдаатай ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтны утас, и-мэйл хаягийг залруулан холбогдож ажиллав.
- Цахим шуудан хүлээж аваагүй, хаяг нь алдаатай эсвэл хаагдсан гэсэн тайлбартай хоршоодод цахим шуудангаар судалгааны асуултыг дахин илгээв.
- Тайлант хугацаанд судалгаа ирүүлээгүй хоршоодын бүртгэлийг давхар хөтлөн судалгаагаа ирүүлэхийг даалгаж ажиллав.
- Судалгааг бөглөх зааварчилгаа байсан хэдий ч дахин тайлбар өгөв.
- Төслийн зорилго, ач холбогдлын талаар тогтмол тайлбарлаж байв.
- Мөн 1 /нэг/ ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтантай СЗХ дээр биечлэн уулзаж тайлбар мэдээлэл өгч ажиллав.

ДУГНЭЛТ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл



“Монгол Улсын
санхүүгийн хүртээмжийг
сайжруулах хөтөлбөр”

“Монгол Улсын
ногоон таксономи”

“Тогтвортой санхүүгийн
үндэсний замын зураг”



Зохицуулагч байгууллагууд


Байгальд ээлтэй ногоон санхүүжилт, хүйсээр ангилсан мэдээ, тайлан

ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтнаас авсан судалгаа



❖ 11 эрх бүхий албан тушаалтан, 8 гишүүн хамрагдав


ХЗХ-ны үйл ажиллагаа эрхэлсэн жил



❖ Үйл ажиллагаа эрхэлсэн дундаж хугацаа 11,4 жил




- ❖ Судалгаа ирүүлсэн хоршоодын нийт гишүүний тоо 48601, 1000-аас дээш тооны гишүүдтэй ХЗХ 8 байна.
- ❖ Нийт ХЗХ-ны 54% нь гишүүн эмэгтэйчүүд (26096) байна.



Монгол Улсын ХЗХ салбар нь нийт гишүүдээс үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтэц хүртэл эмэгтэйчүүдийн хувь оролцоо өндөртэй салбар байна.

Гишүүдийн дундаж тоо



1. **Нийлүүлэлт талаас ХЗХ гишүүдэдээ ижил тэгш боломж бололцоог олгодог, хүйсээр ялгаварласан нөхцөл, шаардлага, хориг тавьдаггүй.**
2. **Эрэлт талаас ХЗХ-ны гишүүн эмэгтэйчүүд халамжийн эдийн засгийн үүрэг хариуцлагатай холбоотой саад бэрхшээл, сорилтыг дурдсан.**
3. **Хадгаламж эзэмшигч эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү.**
4. **Бөөний/ жижиглэнгийн худалдаа, машин, мотоцикл засвар, үйлчилгээ, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас/ан агнуурын салбарт эмэгтэйчүүдийн зээлийн чанар сүүлийн жилүүдэд муудсан.**
5. **Ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, ангилал, тавигдах шалгуур үзүүлэлт, нөхцөл, хэмжих үзүүлэлтийг тодорхойлох, сурталчлах, мэдээлэл хүргэх, сургах шаардлагатай. Үр дүнг хэмжих, үнэлэх, дүгнэх бодлого, журам, заавар, арга зүй дутагдалтай.**
6. **Ногоон санхүүжилтийг хөгжүүлэхэд ХЗХ-ны дийлэнхэд хөнгөлөлттэй санхүүжилт, төсөл хөтөлбөр, (санхүүгийн шууд дэмжлэг) шаардлагатай.**
7. **Зарим ХЗХ-нд цаас, ус, эрчим хүч хэмнэх, мод, цэцэг тарих, дахин боловсруулах зэрэг байгальд ээлтэй зан үйлийг зохион байгуулдаг сайн жишиг байна.**

8. ХЗХ-ны гишүүн эмэгтэй БЖДҮ эрхлэгчдийн олонх хөрөнгийн эзэмшлийн хувьд харьцангуй бие даасан, хараат бус.

9. Байгальд ээлтэй ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл/сорилтууд:

- (1) хөнгөлөлттэй санхүүжилт байхгүй
- (2) мэдээлэл дутмаг эсвэл байхгүй
- (3) цаг агаар, улирлын таатай бус байдал
- (4) ажиллах хүч дутмаг

10. Төрөөс ХАА чиглэлд фермерийн үйлдвэрлэл, аж ахуйг дэмжих, өрхийн хэмжээнд хаягдал дахин боловсруулах ажлыг хүүгүй зээлээр дэмжих, ойн аж ахуйг хамгаалах, усжуулах, цөлжилтөөс хамгаалах, малын түүхий эд боловсруулах тоног төхөөрөмжийг бодлогоор дэмжих, арьс шир, ноос ноолуурын анхан шатны боловсруулалт хийх, боловсон хүчин бэлтгэх, эрчим хүч, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилтийн дэмжлэгийг хүсжээ.

Жендэрийн мэдрэмжтэй байгальд ээлтэй технологийн хэрэгцээний үнэлгээ хийх шаардлагатай.

11. Мэдээллийн урсгалыг тогтмол хангах, жендэрийн тоон болон чанарын хяналт, тайлагналыг гүнзгийрүүлэх шаардлагатай.


12. Ногоон санхүүжилтийн сайн туршлага, загварыг баримтжуулах замаар суралцах, туршлага боломжийг хуваалцах шаардлагатай.

ХЗХ-ны гишүүн БЖДҮ эрхлэгчдээс авсан судалгаа



Судалгаанд хамрагдагсадын 54% нь эмэгтэй. Мөн судалгаанд хамрагдсан нийт гишүүний 61 нь хуулийн этгээд бөгөөд үүнээс 35 нь ХХК байна.

Гишүүдийн хүйсийн харьцаа



❖ Хөдөө орон нутгаас 942 ХЗХ-ны гишүүд судалгаанд хамрагдсан бол Улаанбаатар хотоос 299 буюу судалгаа ирүүлсэн нийт гишүүний 23.2% хамрагдсан.


	Насны ангилал	Гишүүдийн тоо	Хувь
1	18-35 настай	182	14.1%
2	36-45 настай	414	32.1%
3	46-55 настай	389	30.2%
4	56 дээш	282	21.9%
5	Хариулаагүй	21	1.6%
	Нийт	1,288	100.0%

❖21 ХЗХ гишүүн энэ асуулгыг бөглөөгүй бөгөөд эдгээр 21 гишүүн нийт судалгаанд хамрагдагсадын 2%-ийг эзэлж байна.

	Гэр бүлийн байдал	Гишүүдийн тоо	Хувь
1	Салсан	20	1.6%
2	Гэрлэсэн	1,117	86.7%
3	Хамтран амьдрагчтай	5	0.4%
4	Ганц бие	56	4.3%
5	Бэлэвсэн	57	4.4%
6	Хариулаагүй	33	2.6%
	Нийт	1,288	100.0%


❖ Судалгаанд хамрагдсан ХЗХ-ны нийт гишүүн эмэгтэйчүүдийн 80.9% хувь нь гэр бүлтэй.

	Үйл ажиллагаа эрхэлсэн жил	БЖДҮ эрхлэгч	Хувь
1	1 жил хүртэл	23	2.2%
2	1-3 жил	87	8.2%
3	3-5 жил	174	16.3%
4	5-8 жил	168	15.7%
5	8-аас дээш жил	615	57.6%
	Нийт	1,067	100.0%



- 1. Гишүүдийн дийлэнх нь төрөөс олгодог бага хүүтэй, урт хугацаат ЖДҮ-ийн дэмжлэгийг бага хүртсэн, орон нутгийн, хөрөнгө, хөдөлмөрөөр хоршсон “туршлагатай зээлдэгч” эмэгтэйчүүд байна.**

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл/үйлчилгээнд шууд оролцогчдын тоо



2. Хөрөнгө түрээслэн үйл ажиллагаа эрхлэх шаардлага нийтлэг байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд шууд оролцогчдын тоо 5 хүртэл- гэсэн ч орон нутгийн хувьд энэ тоо 21-ээс дээш байгаа нь түрээс, түүхий эд, тээвэрт их төлбөр төлж байгаатай холбоотой. Иймд орон нутгийн ХЗХ-ны гишүүд өртгийн сүлжээндээ шинжилгээ хийж, зардлаа бууруулах боломж эрэлхийлэх хэрэгтэй.

Зээл авч чадаагүй шалтгаан



3. Зээл авч чадаагүй гол шалтгаан: “хүү өндөр, хугацаа богино, хэмжээ бага, барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй”- гэж тодорхойлсон. ХЗХ эх үүсвэрийн дутагдалтай байгаа нь судалгаагаар илэрхий тул ХЗХ-ны гишүүдийн хэрэгцээнд тохирох нэмэлт эх үүсвэрийн сувгийг хуулийн хүрээнд бүрдүүлэх шаардлагатай.

	Зээлдүүлэгч	БЖДҮ эрхлэгч	Хувь
1	Банкнаас	518	38.1%
2	Төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл	42	3.1%
3	ББСБ	70	5.1%
4	ХЗХ	715	52.6%
5	Ломбард	-	0.0%
6	Хувь хүн	2	0.1%
7	Бусад	13	1.0%
	Нийт	1,360	100.0%


4. Зээлийн нөхцөлд хамгийн их хөнгөлөлт /зээлийн хүү, хугацаа/ үзүүлдэг хуулийн этгээд нь ХЗХ, удаад нь банк эрэмбэлэгдсэн ба ХЗХ, банкнаас зээл хамгийн их олгосонтой холбоотой юм.

5. “Эх үүсвэрийн хэмжээ бага, хугацаа богино, хүү өндөр, барьцаа хөрөнгийн үнэлгээ бага, бүрдүүлэх бичиг баримт их”- зэрэг голлох бэрхшээл байна. Хүссэн хэмжээний санхүүжилт олгох бололцоо бага, хүртээмж хязгаарлагдмал, зээлийн нөхцөл хатуу, гишүүд нь барьцаа хөрөнгийн ба бизнес эрхлэх мэдээлэл дутуу, түрээсийн зардал өндөр, БЖДҮ эрхлэгчдэд зориулсан төрийн дэмжлэг дутагдалтай байгааг судалгаа харуулж байна. Гишүүдэд зээл олгоход тавигдах шаардлага, зээлийн нөхцөлийг бууруулах боломж эрэлхийлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бүрдүүлэх гарц, сувгийг хайх зайлшгүй шаардлагатай.

6. Гишүүдийн дийлэнх нь хүйсийн ялгаварлалтай холбоотой бэрхшээлтэй тулгарч байгаагүй гэв. Судалгаанд хамрагдагсадын 11% нь гэр бүлийн гишүүдийн зүгээс сөрөг, заналхийлсэн, дарамтлах хандлага, үйлдэлтэй тулгарсан, аюулгүй байх боломж хязгаарлагдмал зэрэг хариулсантай холбоотойгоор хүйсээр ялгаварлан гадуурхахыг бууруулах ажлын идэвхийг зогсоолгүй, үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай. Хүүхэд, өндөр настан, асаргаа шаардлагатай хүмүүсээ харж, асрах үүрэг эмэгтэйчүүдэд илүү ногддог ч энэ асаргаа халамжийн эдийн засгийн үүрэг хариуцлагыг ихэвчлэн үл тоомсорлодог. Эдийн засгийн халамжийг дэмжиж, хүйсийн ялгаварлал гаргахгүй байх нөлөөллийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай.


Аж ахуй эрхлэхэд хүйсийн ялгаварлалтай холбоотой тулгарсан хүндрэл

- Гэр бүлээ асрах, халамжлах хэрэгтэй учраас аж ахуйн үйл ажиллагаанд оролцох цаг хязгаарлагдмал
- Нийгмийн болон бизнес дэх жендэр/эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголт хүндрэл учруулдаг
- Гэр бүлийн гишүүдийн зүгээс сөрөг, заналхийлсэн, дарамтлах хандлага, үйлдэлтэй тулгарч байсан
- Үйл ажиллагаа эрхлэхэд амар тайван, аюулгүй байх боломж хязгаарлагдмал
- Хүйсийн ялгаварлалтай холбоотой хүндрэл бэрхшээл тулгарч байгаагүй
- Мэдэхгүй
- Бусад



- 7. ХЗХ-ны дийлэнх гишүүдэд бизнес төлөвлөгөө боловсруулах, татвар, бүртгэл тооцоо, маркетинг, борлуулалттай холбоотой чадвар онц шаардлагатай тул СЗХ, ХЗХ-ны холбоо нь ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтнуудтай хамтран чиглэлийн сургалтыг жилийн хуваарьт оруулан, ХЗХ-ны гишүүдийг орон нутаг, УБ хотоор ялган, хэрэгцээт сургалт мэдээллийг ХЗХ-ны гишүүдэд олгож, тэднийг чадавхжуулах шаардлагатай байна.**
- 8. ХЗХ-ны гишүүдийн дийлэнх нь зээл олгоход байгальд ээлтэй байх шаардлага тавигдаагүй, аж ахуйн үйл ажиллагааны хог хаягдлыг шууд хаядаг, бараа материал, бүтээгдэхүүнийг дахин ашиглах, засварлах, шинэчлэх зэргээр үйлдвэрлэл хэрэглээний загварыг хөгжүүлэх боломжтой- гэж хариу ирүүлсэн нь ХЗХ-ны салбарт байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн санаачилга хараахан нэвтрээгүй байгаатай холбоотой юм.**

Бараа материал, бүтээгдэхүүнийг дахин ашиглах, засварлах, шинэчлэх, дахин боловсруулах, түрээслэх зэрэг үйлдвэрлэл, хэрэглээний загваруудыг хөгжүүлэх боломжтой юу?



Байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, тойрог эдийн засгийн загвар хөгжүүлэх талаар сурталчлан таниулах үйл ажиллагааг нэмэгдүүлбэл урт хугацаанд бараа бүтээгдэхүүнийг эргэлтэд дахин оруулж, хог хаягдлын хэмжээг бууруулах хэрэгцээ, сонирхол ХЗХ-ны гишүүдийн дунд өндөр байна.

- 9. Байгальд ээлтэй ногоон санхүүжилт авах хэрэгцээ бүхий нийт гишүүний дийлэнх нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, газар тариалан, мал аж ахуйн салбарт аж ахуй эрхэлдэг орон нутгийн, дээд боловсролтой, 46-55 насны, гэр бүлтэй, ХЗХ-ны гишүүн эмэгтэйчүүд байна. Энэ бүлгийн хүмүүс органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл, байгальд хөнөөл багатай цэвэр түүхий эд ашиглах, хог хаягдлыг багасгаж, хөрсний эрүүл мэндийг нэмэгдүүлдэг газар тариалан эрхлэх чиглэлээр санхүүжилтийг төсөл хөтөлбөр, ХЗХ болон банкнаас авах хэрэгцээтэй байна.**
- 10. Мөн ХЗХ-ны гишүүн БЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө барьцаалж 10,0-50,0 сая төгрөгийг жилийн 3% хүртэлх боломжит хүүтэй, 5-аас дээш жилийн хугацаагаар авах санхүүгийн хэрэгцээтэй орон нутгийн ХЗХ-ны гишүүн эмэгтэйчүүд байгаа нь судалгааны үр дүнд харагдав.**

Хэрэв ХЗХ-ны гишүүн БЖДҮ эрхлэгчдэд хэрэгцээт байгальд ээлтэй ногоон санхүүжилт олгох тохиолдолд түүхий эд, бараа материалын үйлдвэрлэлд хэмнэлт бий болж, хог хаягдлын хэмжээ буурна гэдэгт ХЗХ-ны гишүүдийн дийлэнх нь итгэлтэй байна. Бодит байдалд ХЗХ-ны дийлэнх гишүүд жилийн 18%-аас дээш хувийн хүүтэй санхүүжилт авсан нь энэхүү судалгааны үр дүнд нотлогдсон ба энэ хүүгийн хувь хэмжээгээр ХЗХ-ны БЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь 100,0-300,0 сая төгрөгийн байгальд ээлтэй ногоон санхүүгийн хэрэгцээтэй байгаа нь авсан зээлийн хэмжээ, хугацаатай уялдаа холбоо тааруу байна. СЗХ-ноос бэлтгэсэн ХЗХ-ны 2022 оны IV улирлын нэгтгэл тайланд хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1,2%, жилийн 14,4% (*хадгаламжийн хүүгийн болон үйл ажиллагааны зардал нь ХЗХ-ны зардлын бүтцийн 92,2% эзэлдэг*) тохиолдолд санхүүжүүлэх эх үүсвэрийн хүү энэхүү хувь хэмжээтэй харьцуулахад илүү байх шаардлагатай тул ХЗХ-ны гишүүн БЖДҮ эрхлэгчдийн байгальд ээлтэй ногоон санхүүгийн хэрэгцээг хангах боломж хязгаарлагдмал байна.

- **Нэгтгэн дүгнэхэд, ХЗХ-ны эрх бүхий ажилтан, гишүүн БЖДҮ-ийн дийлэнх нь ногоон санхүүжилтийн талаар, ялангуяа энэ нь нийгэм, байгаль орчны зорилгодоо хүрэхэд хэрхэн тусалж, өрсөлдөх чадвар, эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх талаар илүү ихийг мэдэх сонирхол, хүсэл эрмэлзэл өндөр байна.**
- **ХЗХ-ны эрх бүхий ажилтан, гишүүн БЖДҮ-ийн дийлэнх нь жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүгээр дамжуулан чадавхаа бэхжүүлэх, сүлжээ байгуулах, зөвлөн туслах, сурталчлах, мөн ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү төрөлжүүлсэн, хүртээмжтэй болгох эрэлт, сонирхолтой байгаа нь суурь чанарын судалгаагаар нотлогдов.**
- **ХЗХ-ны эрх бүхий ажилтан, гишүүдийн дийлэнх нь ногоон санхүүжилтийн тухай ойлголт, үр өгөөжийн талаар мэддэг ч түүнийг олж авах, бизнэстээ үр ашигтай ашиглах, хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар дутмаг байна.**

- **ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтан, гишүүдийн ногоон санхүүжилтийг нэвтрүүлэхэд тулгарч буй гол бэрхшээлүүд нь бодлого, журам, заавар, дэмжлэг, сургалт, бүтээгдэхүүн үйлчилгээ байхгүй, санхүүгийн эх үүсвэр, техникийн чадавх хязгаарлагдмал, зээлийн хүү өндөр, мэдээлэл дутмаг байна.**
- **Судалгаанд мөн жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийг сайжруулах зарим сайн туршлага, боломжуудыг онцлон тэмдэглэсэн, тухайлбал, жендэрийн тэгш байдлыг хангах өнөөгийн тогтолцоо, арга хэрэгсэл, уур амьсгалын үйл ажиллагаанд гишүүдийн эрх мэдэл, оролцоог дэмжих санаачилга, төслүүд, бусад оролцогчидтой хамтран ажиллах боломжит түншлэл, хамтын ажиллагаа зэрэг.**
- **ХЗХ-ны салбарт нийлүүлэлт тал дээр хүйсийн ялгаварлал бага байгаа бол эрэлт хэрэгцээ талаас эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээлүүд байгаа тул ХЗХ-ны байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн салбарын мэдлэгийн ойлголт зөрүүг багасгах шаардлагатай байна.**

ХЗХ-ны салбарт хүйсийн ялгаварлал бага, харин байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн талаарх ерөнхий болон нарийвчилсан мэдээлэл хангалтгүй тул ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтан, гишүүн БЖДҮ эрхлэгчдэд ногоон санхүүжилтийн талаар таниулга, ухуулга, сурталчилгааг хүргэх ажлыг эрчимтэй хийж, мэдлэгийг тэлэн, чадавхыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Эхний алхам бол аж ахуйн нэгжийн “ногоон” бүрдэл, бүтцийг тодорхойлж, БЖДҮ-д нийцүүлж болох нийтлэг үзүүлэлтүүдийг сонгох явдал юм. Дээрх ажлуудыг гүйцэтгэсний үр дүнд ХЗХ-ны салбарын ногоон санхүүжилтийн хөгжил хурдсах ба материал түүхий эдийн хэмнэлт бий болж, тойрог эдийн засгийн загвар нэвтрэн, хог хаягдлын хэмжээ буурах боломж өргөнөөр бий болох юм.

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-т дурдсаны дагуу банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцын 5-аас доошгүй хувийг 2030 он хүртэл ногоон зээлээр бүрдүүлэх зорилтыг хангах, Парисын хэлэлцээрт нэгдсэн зорилтод хүрэх боломж бүрдэх юм.

Жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийг нэмэгдүүлснээр ХЗХ-ны хувьд зардал буурч, бүтээмж нэмэгдэн, бүтээгдэхүүний нэр хүнд өсөж, зах зээлд эзлэх байр суурь нэмэгдэх бол ажилтнуудын хувьд идэвх хандлага нэмэгдэн сайжирч, багийн ажиллагаа дээшлэх ба бүтээмж нэмэгдэх боломжтой. Харин ХЗХ-ны харилцагч, хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамж нэмэгдэн, байгальд ээлтэй хэрэглээ, дадал бий болох үр дүнтэй юм.


Хүртээмжтэй ногоон санхүүгийн 4 бодлого



Хангамжийн бодлого

Мэргэшсэн ашиг хүртэгчдэд ногоон төсөл, арга хэмжээний санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бодлого.

Тухайлбал: Санхүүгийн эх үүсвэрийг зохицуулалтын арга хэмжээ авах замаар хүртээмжтэй ногоон төслүүдэд үр дүнтэй хуваарилж, холбогдох төлбөрийн системээр дэмжинэ.





Урамшуулал/дэмжих бодлого

Хувийн хэвшилд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үйлчилгээг санал болгоход бэлтгэхэд чиглэсэн бодлого юм.

Тухайлбал: Хувийн хэвшлийг ногоон төсөл эсвэл уур амьсгалын үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн ашиг хүртэгчдээс мэдлэг дээшлүүлэх, мэдээлэл солилцох, чадавхыг бэхжүүлэх, мэдээлэл цуглуулах замаар санхүүгийн үйлчилгээ авахад бэлтгэнэ.

Урьдчилан сэргийлэх бодлого

Урьдчилан сэргийлэх бодлого нь сөрөг үр дүн гарсны дараа биш, гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэхэд чиглэнэ. Өөрөөр хэлбэл, урьдчилан сэргийлэх бодлого нь санхүү, нийгэм, байгаль орчны эрсдэлийг бууруулах замаар хүсээгүй үр дагавраас зайлсхийх, эрсдэлийн үнэлгээний шинэ удирдамж гаргах замаар санхүүгийн салбарт стандартыг бий болгоход чиглэнэ.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн гишүүд өргөн хүрээний бодлого баримталж байгаа хэдий ч уур амьсгалын өөрчлөлтийн салбарт төв банкууд, зохицуулагчид улам бүр чухал үүрэг гүйцэтгэх чиг хандлага тэргүүн ээлжинд байсаар байна.





Хамгааллын бодлого

Хамгааллын бодлого нь даатгал, зээлийн баталгаа, нийгмийн төлбөр эсвэл эрсдэлийг хуваалцах бусад механизмаар болзошгүй алдагдлыг “нийгэмжүүлэх” замаар санхүүгийн эрсдэлийг бууруулах чиглэлийн бодлого.



Хадгаламж, зээлийн хоршооны хувьд

1. Хангамж

- I. Байгууллагын эрхэм зорилго, зорилт, бодлого, стратеги, засаглалд байгаль орчны/ тойрог эдийн засгийн зарчим, жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоог тусгах;
- II. Жендэрийн мэдрэмж бүхий ногоон бүтээгдэхүүний талаарх бодлого, журам, удирдамж, түүнчлэн нөхцөл, үйлчилгээг боловсруулж, үе шаттайгаар ашиглалтад оруулах;
- III. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алиных нь хүсэлтийг тусгасан байгаль орчинд ээлтэй, хог хаягдлыг бууруулдаг шинэ технологи, дижитал платформ нэвтрүүлэх;
- IV. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэмүү өртгийн сүлжээний бүтцэд анхаарч, тойрог эдийн засгийн зарчмаар ажиллах, зээлийн эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх – эмэгтэй, эрэгтэй гишүүдтэй хамтран тэдний үйл ажиллагаанд тохирсон удирдамж боловсруулах.
- V. ХЗХ-ны эрх бүхий ажилтан, гишүүн БЖДҮ-ийн дунд жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх;

VI. ХЗХ-ны гишүүн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ, хүсэл сонирхол, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг харгалзан илүү зохицсон, хүртээмжтэй ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх;

VII. ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтан, гишүүдийн дунд ногоон санхүүжилтийг дэмжих гол боломжууд нь санхүүгийн боловсрол, чадавхыг дээшлүүлэх, жендэрт нийцсэн ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, мэдээлэл солилцох, бусдаас суралцах сүлжээ, платформ бий болгох, сурталчлах;

VIII. ХЗХ-ны эрх бүхий ажилтнууд жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийг хөгжүүлэхэд өөрсдийн үүрэг, манлайллыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээ авахыг зөвлөж байна, тухайлбал, гишүүдийн мэдлэг, чадавх, сурталчилгааг нэмэгдүүлэх, байгууллагын чадавх, үүрэг амлалтыг бэхжүүлэх, хамтын ажиллагаа, зохицуулалтыг дэмжих, одоо байгаа нөөц, платформыг ашиглах, хариуцлагыг баталгаажуулах, суралцах.



2. Урамшуулал

- I. Бизнесийн үйл ажиллагаанд байгальд ээлтэй түүхий эдийн ногоон худалдан авалтын жишээг олж, олон нийтэд түгээх, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүсэх хог хаягдлын хэмжээг инновац дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар бууруулах, бизнес-хэрэглэгчдийн хооронд дахин ашиглах, сэргээн засварладаг загварыг бий болгох;**
- II. Хөдөлмөр болон хөрөнгөөр хамтрах замаар хамтран ажиллаж, үйл ажиллагааны зардал /түрээс, түүхий эд, тээврийн зардал зэрэг үндсэн зардал/-ыг бууруулах шинэлэг ногоон бизнесийн загварыг дэмжих;**

III. Жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоо, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийг хариуцах ажилтан, мэргэжилтнүүдийг байгууллагын хүрээнд томилж, сургаж, хөгжүүлэх; Эдийн засгийн гадаад хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх зарчмууд болон тойрог эдийн засгийн зарчмуудын талаар нэг хүнээс нөгөөд чиглэсэн баримжаа олгох сургалтуудыг тогтмол явуулах;

IV. Байгаль орчинд ээлтэй зан үйлийг байгууллагын хүрээнд хөхиүлэн дэмжих, манлайлагчдыг тодруулах, сурталчлах, шагнаж урамшуулах, удирдлагын загвараа бусад ХЗХ-той хуваалцах;

V. Байгаль орчин, нөхөн сэргээлт, дасан зохицох чадварыг бий болгох үйл ажиллагаа болон системд идэвхтэй манлайлах.



3. Хамгаалал

I. Байгаль орчинд ээлтэй ажлын гүйцэтгэл, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тогтмол ил тод тайлан хийх, мөн алдаанаасаа суралцах, хуваалцах зорилгоор албан бус аудит хийх;

II. Эрсдэл, хяналтын тогтолцоог бий болгох /зээл, эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн бодлогод тусгах; зээл олголт, эргэн төлөлт, эрсдэлтэй, анхаарал татахуйц зээлтэй ажиллах; хөрөнгийг ангилах; хөрөнгийн эрсдэлийн санг бий болгох болон зарцуулах; барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх журам, заавар, хадгаламжийн ерөнхий нөхцөл, зээлийн хүүгийн шимтгэл, зээл, санхүүгийн түрээс, барьцаа, баталгаа, хадгаламжийн гэрээ, дансны төлөвлөгөө гэх мэтэд байгаль орчинд ээлтэй ногоон санхүүжилтийн зарчим, шаардлага тусгагдсан байх ёстой/.



4. Урьдчилан сэргийлэх

- I. Хүйсээр ялгаварлах, нийгмээс гадуурхан тусгаарлахын эсрэг, мөн байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих; Бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийн сүлжээний бүрдэлд анхаарал хандуулах, тойрог эдийн засгийн зарчмаар ажиллан, зээлийн эрсдэлийг бууруулах, эрсдэлээс сэргийлэх;
- II. Олон улсын гэрээ, конвенцоор хориглосон, байгаль орчинд халтай үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх, мөн санхүүжүүлэхгүй байх тухай заавар, зөвлөгөөг үйл ажиллагааны бодлого, журамдаа тусгах;
- III. Жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийг ХЗХ-ны гишүүдийнхээ дунд сурталчлах замаар Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ), үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах.



Анхаарал хандуулсанд баярлалаа.

Төслийн дотоодын зөвлөх:

Т.Очирхүү

Утас: 91912130

И-мэйл: ochirkhuu.t@gmail.com